



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/144

Мандалговь

Үнэлгээний баг томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1, Засгийн газрын 2020 оны 218 дугаар “Журам шинэчлэн батлах тухай” тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түшинг үнэлэх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын ажилтан, албан хаагчдын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас бүтэн жилээр үнэлж дүгнэх үнэлгээний багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Багийн ахлагч:

Г.Самданцоодол

(Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсийн дарга)

Гишүүд:

Н.Түвшинжаргал (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Н.Эрдэнэ-Очир (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Г.Энхтайван (Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Л.Баярсайхан (Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Ш.Гансүх (Цэргийн штабын дарга)

М.Болор-Эрдэнэ (Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Х.Мөнхсаруул (ТЗУХ-ийн Хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн)

2. Аймгийн Засаг даргын тамгын газрын ажилтан, албан хаагчдын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар “Аргачлал, загвар батлах тухай” тушаалаар батлагдсан аргачлалын дагуу үнэлэн дүгнэж, 6, 12 дугаар сарын 20-ны дотор танилцуулахыг үнэлгээний баг, (Г.Самданцоодол)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.ДОРЖБАТ

